



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2012 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Сервер болон сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: ST-2012/02

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчдоос ажлын хэрэгцээнд зориулан сервер болон сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах багцтай байна. Үүнд:

Багц 1: Сервер төхөөрөмж

Багц 2: Сүлжээний тоног төхөөрөмж

Тендерийн бичиг баримтыг бичгээр хвсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 80,000 (наян мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хвчинтэй байна. Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө.

Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана.

Тендерийг 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хвсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Улаанбаатар 15160, Монголбанкны “А” байрны 1 давхар, 2 тоот өрөө

Утас: 11-327048, Факс: 976-11-311471